



**ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 27 өдөр

Дугаар 8/104

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59 дүгээр зүйлийн 59.1.1, Засаг даргын Мөрийн хөтөлбөрийн 2.4.12 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн сумын Ноён Мөрөн үндэсний бөхийн холбоо нь Үндэсний баяр наадмын бөхийн бэлтгэлд гарсантай холбогдуулан дэмжлэг үзүүлсүгэй.
2. Дээр дурдсан дэмжлэгт зориулан Засаг даргын Мөрийн хөтөлбөрийн зардлаас 500 000 (таван зуун мянган) төгрөгийг зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын Нягтлан бодогч (Б.Нандин-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.
3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Мягмаржав)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.БАТЦООЖ